



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар

А/243

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг нийслэлийн хэмжээнд судалж, санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2.Нийслэлийн нутгийн захиргааны болон өмчит байгууллагаас төрийн нэрийн өмнөөс үзүүлж байгаа үйлчилгээнээс сар бүр 3 үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр санал боловсруулж, нийслэлийн Засаг даргад болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан Ажлын хэсэгт танилцуулж, хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг (Ж Сандагсүрэн)-т үүрэг болгосугай

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д СУМЪЯАБАЗАР

1110203998

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
сарын ...-ны өдрийн
захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч

Дэд дарга:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

-Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны дарга;

Гишүүд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар;

-Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны хэлтсийн дарга нар;

-Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нар;

-Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын дарга;

-Үйлчилгээ үзүүлж байгаа нийслэлийн өмчит хуулийн этгээдийн дарга нар;

Нарийн бичгийн дарга:

-Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга.